

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 5-р сарын 21
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201901450

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **Бор-Өндөрийн УБҮ-ийн дулааны станцын KE-25-14C маркын зуухны механик ул ширэмтэй галын хотлыг шинэчлэх ажил**–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. **Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.**

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн аль нэг жилд борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 50 хувиас багагүй.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2017, 2018 он

Туршлагын талаар мэдээлэл: Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын жагсаалт, мөнгөн дүнгийн хамт ирүүлнэ.

Тусгай зөвшөөрөл: Зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт **3 300 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 6-р сарын 21-ны өдрийн 15:00 цаг**–аас өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба тендерийг **2019 оны 6-р сарын 21-ны өдрийн 15:30 цаг** -т цахимаар нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **эрхгүй**
Дотоодны давуу эрх тооцох эсэх: **тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“Монголросцветмет” ТӨҮГ, УБ, БЗД, Энхтайваны өргөн чөлөө-98
(өрөөний дугаар 409)
утас:458401/188, факс: 458380